

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 26/05

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, инфляцын өрнөл, эдийн засгийн төлөв болон гадаад орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах талаар хэлэлцлээ.

Хуралдааны эхний хэсэгт Мөнгөний бодлого, судалгааны газар (МБСГ)-аас эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв болон гадаад орчинд гарсан өөрчлөлтүүдийн талаар танилцуулав.

Урсгал данс болон санхүүгийн данс аль аль нь ашигтай байснаар төлбөрийн тэнцэл 2026 оны эхний хагаст 567 сая ам.долларын ашигтай байлаа. Нүүрсний экспортын биет хэмжээ өссөн, алт зэсийн үнэ түүхэн дээд хэмжээнд хүрсэн зэрэг нь экспортын орлогыг нэмэгдүүлж байгаа бол санхүүгийн дансны хувьд банк болон хувийн секторын хөрөнгийн орох урсгал сайн байсантай холбоотойгоор ашигтай гарав.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2026 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж, 2.1 их наяд төгрөгт хүрлээ. Нэг талаас цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өсөлт болон эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор татварын орлого бүрдүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 их наяд гаруй төгрөгөөр нэмэгдсэн боловч нөгөө талаас төсвийн зардал өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн.

Үргэлжлүүлээд мөнгө, зээлийн үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтийн талаар танилцууллаа. Төлбөрийн тэнцэл, гадаад валютын цэвэр орох урсгал сайжирсантай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжиж байна. Зээлийн өсөлтийн хурд 2026 оны эхний 6 сарын байдлаар 15.8 хувьтай бөгөөд цаашдын төсөөллийн хувьд өмнөх төсөөллөөс томоохон өөрчлөлтгүй байгааг дурдав.

Цаашлаад инфляцын өрнөл, цаашдын төлөв болон эрсдэл, тодорхой бус байдлын талаар дэлгэрэнгүй танилцууллаа. Жилийн инфляц 2026 оны 7 дугаар сард улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод 13 хувьд хүрсэн байна. Шатахуун, хүнс, төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлэв. Харин суурь инфляц энэ оны 7 дугаар сард хүлээлтээс бага зэрэг эрчимжлээ. Үүнд импортын автомашины үнэ болон шатахууны үнийн дам нөлөөгөөр үйлчилгээний үнэ өссөн зэрэг нь нөлөөлөв. Түүнчлэн, шатахууны үнийн өсөлт нь үйлдвэрлэлийн өртөг, бараа, үйлчилгээний үнэд нөлөөлөх замаар суурь инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Харин махны үнийн өсөлт баяр наадмын дараа алгуур саарч эхэлсэн нь инфляц нэмэгдэх дарамтыг бууруулах эерэг дохио болж байна. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт үргэлжлэн нэмэгдэж, цаашид хүнсний инфляц буурах хүлээлт хэвээр хадгалагдлаа. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлтийн гаралтай шокийн нөлөө арилж, инфляц ирэх оны хоёрдугаар улирлаас төв банкны зорилтот интервал руу дөхөх хүлээлттэй байна.

Иргэдийн болон аж ахуй нэгж (ААН), шинжээчдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны үр дүнгээр инфляцын хүлээлт өмнөх улирлаас нэмэгдсэн хэдий ч чанарын

хариултад суурилсан чиглэлийн индексийн үр дүнгээр инфляц цаашид улам өснө гэсэн хүлээлт саарч байгааг танилцууллаа.

Шатахууны нийлүүлэлтийн хязгаарлалт удаан үргэлжлэх, гадаад үнийн өсөлт нэмэгдэх зэрэг инфляцыг эрчимжүүлэх эрсдэлт хүчин зүйлс өндөр хэвээр байгааг онцлов.

Эдийн засаг 2026 оны эхний 5 сард 7.3 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын өсөлт голлон бүрдүүлж байна. Зэсийн үнэ өсөж, нүүрсний экспортын биет хэмжээ оны эхнээс эрчимтэй нэмэгдэж байгаа нь худалдааны нөхцөл сайжрах, төлбөрийн тэнцэл ашигтай гарахад нөлөөлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжиж байна. Энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 6 хувь болгож нэмэгдүүллээ. Үүнд, уул уурхайн салбарын хувьд нүүрсний үйлдвэрлэл, олборлолтын биет хэмжээг нэмэгдүүлсэн нь өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байгаа бол нөгөө талдаа зэсийн баяжмал дахь алтны агууламж буурах нь сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Харин уул уурхайн бус салбарын хувьд хөдөө аж ахуй, боловсруулах салбараас бусад салбарын өсөлт харьцангуй нам түвшинд байх төлөвтэй байна. Дунд хугацаанд томоохон төслүүд болон цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажил үргэлжлэхтэй холбоотойгоор уул уурхайн бус салбар тэр дундаа барилга, үйлчилгээний салбар нийт эдийн засгийн өсөлтийг тэтгэхээр байгааг танилцууллаа.

Хуралдааны үеэр суурь төсөөллөөс гадна эдийн засгийн төлөвт нөлөөлж болзошгүй голлох эрсдэлт хүчин зүйлс болон түүнд үндэслэн боловсруулсан хувилбар төсөөллүүдийн талаар гишүүдэд танилцуулав. АИ-92 шатахууны хязгаарлалт энэ оныг дуустал үргэлжлэх нөхцөлд шатахууныг өргөнөөр ашигладаг өрхүүд болон аялал жуулчлалын салбарт учрах сөрөг нөлөө болон түүнийг дагасан дам нөлөө, инфляц өсөх эрсдэлийн талаарх тооцоо, судалгааг танилцуулав. Түүнчлэн бодлогын хүүг өөрчлөх, банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өөрчлөх бодлогын хувилбаруудын талаар авч үзлээ.

Ийнхүү эдийн засгийн дотоод, гадаад орчны өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөв болон эрсдэлт хүчин зүйлсийг харгалзан инфляцын хүлээлтийг тогтворжуулах, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн дам нөлөөг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12.5 хувьд хүргэх саналыг танилцуулж, гишүүд тус саналын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ.

МБХ-ны гишүүд жилийн инфляц улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод 13 хувьд хүрч эрчимжсэн нь хүнс болон шатахууны үнийн өсөлт буюу нийлүүлэлтийн шинжтэй хүчин үйлсээс үүдэлтэй бөгөөд геополитикоос үүдэлтэй хүндрэлтэй нөхцөл байдал даамжрах болон гадаад, дотоод үнийн тодорхой бус байдал өндөр байгаа, томоохон төв банкууд бодлогын хүүгээ өсгөх хүлээлт давамгайлж байгаа зэргийг харгалзан мөнгөний бодлогыг чангаруулах нөхцөл бүрдсэн гэж үзлээ.

Цаашлаад, гишүүд инфляцын хүлээлт нэмэгдэх нь иргэд, аж ахуйн нэгжийн хэрэглээний шийдвэрт нөлөөлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг илүү өргөн хүрээтэй, удаан үргэлжлэх эрсдэлтэйг онцлон, инфляцын хүлээлтийг тогтворжуулах, улмаар инфляцыг зорилтот түвшинд бууруулахад бодлогын хүүг нэмэгдүүлэх нь зүйтэй гэдэгт санал нэгдэв.

Мөн гишүүд төсвийн бодлогын тэлэлт, ялангуяа сонгуулийн мөчлөгтэй уялдсан төсвийн зардлын өсөлт нь дотоод эрэлтийг нэмэгдүүлэх замаар инфляцад нэмэлт дарамт болж болзошгүй бөгөөд төсвийн тэлэлтийн эрсдэлтэй холбогдуулан төсөв, мөнгөний бодлогын уялдаа, засаглалыг сайжруулах шаардлагатайг онцолж, суурь шинэчлэл, өөрчлөлт хийхгүй бол мөнгөний бодлогын орон зай хумигдаж байгааг онцлон тэмдэглэв.

Түүнчлэн, зарим гишүүд төлбөрийн тэнцлийн ашигтай холбоотой гадаад валютын цэвэр орох урсгал сайжирсан, банкны системийн гадаад цэвэр актив нэмэгдсэнтэй холбоотой мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжсэн тул гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийг хамгаалах, импортын өсөлтийг бууруулах зорилгоор ЗБН-ийн хувь хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Өөр нэг гишүүний зүгээс уул уурхайн гол бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнэ өсөж, экспортын биет хэмжээ оны эхнээс эрчимтэй нэмэгдсэн, төлбөрийн тэнцэл ашигтай гарч эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн зэрэг дотоод эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал төсөөллөөс сайн байгааг дурдлаа.

Ийнхүү МБХ-ны гишүүд инфляцын цаашдын төлөв, эдийн засгийн өсөлтийн суурь төсөөлөл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзэж нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт өргөн хүрээний инфляц болж даамжрах, инфляцын хүлээлт тогтворгүйжих эрсдэлээс сэргийлэхийн тулд бодлогын төлөвийг чангаруулах нь зохистой гэсэн байр суурь илэрхийллээ. Улмаар, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.5 хувьд хүргэх; банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар өсгөж, 14.5 хувьд хүргэх саналыг бүх гишүүд дэмжсэнээр МБХ-ны ээлжит бус хуралдаан өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит бус хурлаараа инфляц, эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоод, гадаад орчны төлөв болон эрсдэлийг харгалзан үзээд,

1. Бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.5 хувьд хүргэх;
2. Банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар өсгөж, 14.5 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

Бодлогын саналын шийдвэр

